



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/Н7

Улаанбаатар хот

Барилга байгууламжийн зураг төсөлд
магадлал хийх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд
орж ажиллах журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Галын аюулгүй байдлын магадлал хийсэн тухай дүгнэлтийн маягт”-ын загварыг хоёрдугаар, “Барилгын зураг төсөл хяналтын болон барилга ашиглалтад хүлээн авах комисст ажиллах чиг үүргийн хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Галын аюулгүй байдлын магадлалын дүгнэлтийн маягт хэвлүүлэх, бүртгэх, хадгалах, тооцоо хийж ажиллахыг Санхүү, ар талын газар (хурандаа Я.Гантөмөр)-т зөвшөөрсүгэй.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн), Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т тус тус даалгасугай


4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” А/288 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
А/Н.Т. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮНД
ОРЖ АЖИЛЛАХ, ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Барилгын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм, галын аюулгүй байдлыг хангуулах норм, стандарт, дүрэм, журам нь энэхүү журмыг хэрэгжүүлэх үндэслэл болно.

1.2. Галын аюулгүй байдлын магадлал хийж дүгнэлт гаргах, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах, үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хэрэглэх хүрээ

2.1. Энэхүү дүрмээр Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 10 дугаар зүйл, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 211 дүгээр тушаалаар батлагдсан Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах, барилга байгууламжийн зориулалт хүчин чадалтай уялдуулан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан (Хяналтын байцаагч) барилга байгууламжийн зураг төсөлд Галын аюулгүй байдлын магадлал хийх, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах ажлын чиг үүргийг тогтооно.

Гурав. Галын аюулгүй байдлын магадлал хийж дүгнэлт гаргах

3.1. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, эрчим хүчний эх үүсвэр, хийн хангамжийн системийн угсралт, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний зориулалтыг өөрчлөхөд гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.1.2, 6.1.3 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.6, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн 5 дугаар зүйл, 5.1, 5.3 дах хэсэгт заасны дагуу галын аюулгүй байдлын дүрэм норм, стандартын шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргана.

3.2. Барилга байгууламжийн Эх загвар зураг (Эскиз) төслийг зөвшилцөхөд дараах баримт бичгийг бүрдүүлж тухайн нутаг дэвсгэрийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

3.2.1. Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн албан хүсэлт (эх хувь);

3.2.2. Газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ, захирамж, кадастрын зураг (хуулбар хувь)

3.2.3. Эх загвар зургийн нүүр хуудас, Барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, технологийн байгуулалтын зураг.

3.3. Барилга байгууламжийн иж бүрэн ажлын зураг төслийг зөвшилцөхөд дараах баримт бичгийг бүрдүүлж тухайн нутаг дэвсгэрийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

3.3.1. Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн албан хүсэлт (эх хувь);

3.3.2. Газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ, захирамж, (Хуулбар хувь)

3.3.3. Техникийн нөхцөл (Цахилгаан, цэвэр бохир, холбоо), төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд Вагоны техникийн үзлэг, засвар. Ерөнхий шаардлага. MNS 6466:2016 стандартын 6.17, 6.20, 6.21, 8 дугаар зүйлийг үндэслэн сэргээх их засвар хийх зөвшөөрөл, дүгнэлт;

3.3.4. Инженер геологийн дүгнэлт;

3.3.5. Архитектур төлөвлөлтийн даалгавар;

3.3.6. Барилгын зураг төслийн иж бүрдэл (Архитектур төлөвлөлт, бүтээц хийц, цэвэр бохир ус, халаалт салхивч, холбоо дохиолол, инженерийн хангамж, гадна ус, цахилгаан, техник технологийн шийдэл, тэдгээрийн тооцооны үндэслэл, загвар зураг, автоматик зураг зэргээс бүрдэнэ);

3.3.7. Тэмдэгтийн хураамж төлсөн баримт (эх хувь) зэрэг материалаас бүрдсэн барилгын зураг төслийг Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь батлагдсан чиг үүрэг, ажлын хуваарийн дагуу барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийж, галын аюулгүй байдлын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргана.

3.4. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногт, 10.1.4-т заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт, 10.1.3-т заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг ажлын 5 хоногт, 10.1.1, 10.1.2-т заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг 1-3 хоногт багтаан хянана. Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.15.-т заасан барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг хянахад ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

3.5. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний загвар болон ажлын зураг төслийн нүүр хуудас дээр дарсан “ХЯНАСАН” гэсэн тусгай тэмдэг, Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчийн холбогдох хуудас дээр дарсан тэмдэг, гарын үсэг, Улсын байцаагчийн зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлтийн хамт баталгаажна.

3.6. Онцгой байдлын байгууллага нь барилгын зураг төслийн галын аюулгүйн дүрэм, норм, стандартын шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж зөвшилцөн, дүгнэлт гаргасан талаар цахим мэдээллийн санг бүрдүүлж, дүнг тайланд тусгана.

Дөрөв. Гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд дүгнэлт гаргах

4.1. Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний галын аюултай бүтээгдэхүүн гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, (гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж) анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4, 16, 17, 19, 23, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн галын аюулгүй байдлын дүгнэлт гаргана.

4.2. Гал түймрээс хамгаалах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гаргах дүгнэлтийг Онцгой байдлын байгууллагын гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч үзлэг шалгалт хийсэн дүнг үндэслэн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд багтаан гаргана.

4.3. Гал түймрээс хамгаалах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гаргах дүгнэлтийг хяналт шалгалт хийсэн гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч,

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 93 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан эрх зүйн баримт бичгийн хэвлэмэл хуудсанд 1 жилийн хугацаатай бичиж олгох бөгөөд хугацаа дууссан тохиолдолд хяналт шалгалтыг дахин хийж гаргана.

4.4.Онцгой байдлын байгууллага галын аюулгүй байдлын дүгнэлт гаргасан талаар цахим мэдээллийн санг бүрдүүлж, дүнг тайланд тусгана.

Тав.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын
бүрэлдэхүүнд орж ажиллах

5.1.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр орж ажиллахад Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасныг болон энэ журмыг баримтална.

5.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүн дараах чиг үүргийг авч хэрэгжүүлнэ.

5.2.1.Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.5-д заасан барилгын үйл ажиллагааны зарчим хангагдсан эсэхийг дүгнэх.

5.2.2.Барилгын тухай хуулийн 14.1, 14.2 дугаар хэсэгт заасан шаардлага хангагдсан эсэхийг дүгнэх.

5.2.3.Барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх.

5.2.4.Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 40.1.4, 40.1.11, 40.1.12-т заасан баримт бичиг, лабораторийн шинжилгээний дүгнэлт болон захиалагчийн баталгаажуулалтад үндэслэн хянаж дүгнэх.

5.2.5.Барилга байгууламжийг барих, ашиглах явцад галын аюулгүй байдлын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдлыг дүгнэх.

5.3.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүнээр орж ажиллахдаа ашиг сонирхлын зөрчилгүй болохыг илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн хуудсыг бөглөж, ашиг сонирхлоос сэргийлэх арга хэмжээ авна.

5.4. Комиссын гишүүнээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухайн барилга байгууламжийн ерөнхий гүйцэтгэгч албан бичиг, гэрэл зургаар материалжуулан, 100 хувь хангуулсан тохиолдолд саналын хуудсыг баталгаажуулна.

Зургаа. Галын аюулгүй байдлын дүгнэлтийг цуцлах,
хүчингүй болгох

6.1.Галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлтийг цуцлахдаа Захиргааны ерөнхий хууль, Гал түймрийн улсын хяналтын дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1.Галын аюулгүй байдлын магадлалын дүгнэлт гаргах, хүчингүй болгох үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан бүтцийн нэгж хяналт тавьж ажиллана.

7.2.Эрх бүхий албан тушаалтан нь Галын аюулгүй байдлын магадлалын дүгнэлт гаргах болон комиссын гишүүнээр орж ажиллахдаа холбогдох хууль дүрэм, журам, норм дүрмийн шаардлагад нийцэхгүй үүрэг даалгавар өгсөн бол хариуцлагыг өөрөө хүлээнэ.

А/МТ
Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ**

.....он сарөдөр


Дугаар

Улаанбаатар хот

Г

Г

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
А/НТ дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙХ БОЛОН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН КОМИСССТ АЖИЛЛАХ
ЧИГ ҮҮРГИЙН ХУВААРЬ

д/д	Онцгой байдлын ерөнхий газар	Төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс
1. Барилгын зураг төслийн хяналт шалгалт		
1.1.	Өндөр, Онцгой төвөгшилтэй цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой зэрэг стратегийн чанартай барилга байгууламжийн зураг төсөл	Бага, дунд төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл
1.2.	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах 10001 м ³ дээш эзлэхүүнтэй болон 6-аас дээш давхар барилга байгууламжийн зураг төсөл	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах 10000м ³ хүртэл эзлэхүүнтэй болон 5 хүртэлх давхар барилга байгууламжийн зураг төсөл
1.3.	Газар дээрх болон газар доорх 1000 м ² -аас дээш талбайтай, 100-аас дээш автомашины зогсоолын барилга байгууламжийн зураг төсөл.	Газар дээрх болон газар доорх 1000 м ² хүртэлх талбайтай, 100 хүртэл автомашины зогсоолын барилга байгууламжийн зураг төсөл.
1.4.	Төв суурин газруудыг хот байгуулалтын баримт бичиг боловсруулалт, ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл	Аймаг, нийслэлийн сум, дүүргийн байгуулалтын баримт бичиг боловсруулалт, ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл
1.5.	Улсын болон бүс нутгийн чанартай уул, уурхайн ашиглалт, олборлолт, боловсруулалтын үйлдвэр тэдгээрийн дагалдах барилга байгууламжийн зураг төсөл	Орон нутгийн чанартай уул уурхайн барилга байгууламжийн зураг төсөл
1.6.	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станц (Газар доорх савтай болон газар дээр ил байрлалтай А төрлийн шатахуун түгээх станц)-ын барилга байгууламж, ОТТТС, АХТШС, АХЦС, ТГСтанцын барилга байгууламж.	Газар дээр ил байрлалтай Б төрлийн шатахуун түгээх станц
1.7.	Хий хангамжийн системийн зураг төсөл.	
2. Барилга байгууламжийн байнгын ашиглалт оруулах чиглэлээр		
2.1.	Цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой зэрэг улсын стратегийн чанартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Бага, дунд төвөгшилтэй үйлчлэх хүрээ нь орон нутгийн шинж чанартай барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.
2.2.	Төв, орон нутагт гал түймрийн онц аюултай барилга байгууламжууд, 10001 м ³ дээш эзлэхүүнтэй 6-аас дээш давхар барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт баригдсан 10000м ³ -ээс доош эзлэхүүнтэй, 6-аас доош давхар барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.

2.3.	Эрчим хүч, Уул уурхай, Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулсан улсын комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдсон тохиолдолд ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Орон нутгийн хэмжээнд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.
2.4.	Шинээр баригдаж байгаа дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн галын аюулгүй байдалд батлагдсан удирдамжаар явцын хяналт тавих.	Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн галын аюулгүй байдалд явцын хяналт тавих болон бүх төрлийн барилга байгууламжийн их болон урсгал засварын ажлыг ашиглалтад оруулах.
2.5.	Газар дээрх болон газар доорх 1000 м ² -аас дээш талбайтай, 100-аас дээш автомашины зогсоолын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Газар дээрх болон газар доорх 1000 м ² хүртэлх талбайтай, 100-аас доош автомашины зогсоолын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.
2.6.	Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, Шатахуун түгээх станц (Газар доорх савтай болон газар дээр ил байрлалтай А төрлийн шатахуун түгээх станц)-ын барилга байгууламж, ОТТС, АХТШС, АХЦС, ТГСтанцын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Газар дээр ил байрлалтай Б төрлийн шатахуун түгээх станцын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах.

Тайлбар:

-Төв орон нутгийн Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч нь Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан нэгжийн шийдвэрээр дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст гишүүнээр ажиллах, зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийж болно.

-Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжийн Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч, эрх бүхий албан тушаалтнаас бусад орон нутгийн Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч, эрх бүхий албан тушаалтан нь хийн хангамжийн системийн ганцаарчилсан баллонт төхөөрөмжийн угсралтын зураг төсөлд магадлал хийнэ.